

**Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны
хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний
хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний дүн
(2025 оны эхний хагас жилийн байдлаар)**

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Засгийн газрын 2024 оны 218 дугаар тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” тус тус батлагдсан.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4. Орон нутгийн хөгжил, 2.1. Чинээлэг Монгол хүн, 2.2. Эрдэм боловсролтой монгол хүн, 2.3. Эрүүл Монгол хүн, 3.3. Эдийн засгийн төрөлжилт, либералчлал, 4.1. Хүний эрх, эрх чөлөө, 4.4. Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх ба амар тайван нийгэм чиглэлийн хүрээнд Эрүүл мэндийн яам үндсэн хэрэгжүүлэгчээр 45, бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэгчээр 22 арга хэмжээ, нийт 67 арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлэхээр байна.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт 2024-2028 онд эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлэх арга хэмжээ хүлээгдэж буй үр дүндээ хүрч байгаа эсэхийг нягтлах, арга хэмжээ тус бүрийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай санал, зөвлөмжийг боловсруулах, шийдвэр гаргагч нарт холбогдох мэдээлэл өгөх зорилгоор явцын хяналт-шинжилгээг хийж гүйцэтгэсэн болно.

Хоёр. Хяналт-шинжилгээ үнэлгээний арга зүй

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын дагуу хяналт-шинжилгээг хийж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийг журмын нэгдүгээр хавсралтын 6.1, 6.5 дугаар заалтад заагдсан бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлэх аргачлалыг баримтлан арга хэмжээний хэрэгжилтийн хувиар тооцон гаргасан.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 2025 оны эхний хагас жилийн байдлаар 27.1 хувьтай үнэлэгдсэн.

2025 онд нийт 67 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс дараах үнэлгээтэй байна. Үүнд:

- “Үр дүнтэй” буюу 85 хувь болон түүнээс дээш хэрэгжилттэй - 10 (15.6%) арга хэмжээ;

- “Үр дүн хүлээгдэж байгаа” буюу 60-84 хувийн хэрэгжилттэй - 6 (9.4%) арга хэмжээ;
- “Үр дүн хангалтгүй” буюу 30-59 хувийн хэрэгжилттэй - 7 (10.9%) арга хэмжээ;
- “Үр дүн гараагүй” буюу 0-29 хувийн хэрэгжилттэй - 41 (64.1%);
- “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” - 3 арга хэмжээ тус тус байна.

“Үр дүн хангалтгүй” буюу 30-59 хувийн хэрэгжилттэй 7 арга хэмжээ байна. Үүнд:

- 1). 173. Хүүхэд хамгааллын кейс менежмент, нийгмийн ажлын мэргэжлийн удирдлагыг хөгжүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээг шаардлагатай хүүхэд бүрд хүргэх (НЭМБГ);
- 2). 291. Анхан шатны спортын сургалт, дасгалжуулалтын үр дүнг сайжруулж, спортын шинжлэх ухаан, спортын анагаах ухааны тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх (ЭТБГ);
- 3). 401. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх (СЭЗБГ);
- 4). 405. Зүрх судасны үндэсний төв байгуулах (СЭЗБГ);
- 5). 421. Эрүүл мэндийн төрөлжсөн мэдээллийн сангийн хүртээмж, ашиглалтыг нэмэгдүүлэх (СТГ);
- 6). 428. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг гадаад улсад урт, богино хугацааны сургалтад багаар хамруулах (СТГ);
- 7). 1250. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх (НЭМБГ).

“Үр дүн гараагүй” буюу 0-29 хувийн хэрэгжилттэй 41 арга хэмжээ байна. Үүнд:

176. Эцэг, эх, хүүхэд, олон нийтэд болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах (НЭМБГ);
187. "Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд" арга хэмжээг хэрэгжүүлэх (НЭМБГ);
194. Идэвхтэй насжилтыг дэмжих цогц үйлчилгээний загварыг нэвтрүүлэх (ЭТБГ);
208. Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг турших (ЭТБГ);
251. Үндэсний баялгийн сангийн нэрийн данс дахь хуримтлалыг эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар зарцуулах боломжийг бүрдүүлэх (СЭЗБГ);
295. Хүн амын идэвхтэй хөдөлгөөн, спортын талаарх мэдлэг, хандлага, дадлыг нэмэгдүүлэх (НЭМБГ);
321. Нялх, балчир насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх (НЭМБГ, ЭТБГ);
388. Нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан үндэсний төв байгуулах (НЭМБГ);

389. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн удирдлага зохион байгуулалтын шуурхай байдал, нотолгоонд суурилсан мэдээлэл судалгаагаар хангах нэгдсэн удирдлагын нэгж байгуулах (НЭМБГ);

390. Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх (НЭМБГ);

391. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх (НЭМБГ);

392. "Эрүүл настан" арга хэмжээг хэрэгжүүлэх (ЭТБГ);

393. Эрүүл мэндэд эрсдэл үүсгэгч хүчин зүйлийг бууруулж хүний амьдрах, ажиллах эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх арга хэмжээ хэрэгжүүлэх (НЭМБГ);

395. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр гар утсанд суурилсан өвчний хяналтын эргэн дуудах болон эрүүл мэндийн мэдээлэл сурталчилгаа нэвтрүүлэх (НЭМБГ);

396. Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах "Эрүүл Монгол хүн" цогц арга хэмжээг хэрэгжүүлэх (НЭМБГ);

399. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх цогц арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжүүлэх (НЭМБГ);

400. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх дэд төв, нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулах (НЭМБГ);

406. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний иргэний эрүүл мэндийн хяналт хийх, эргэн мэдээлэх чадавхыг бэхжүүлэх (ЭТБГ);

407. Яаралтай, түргэн тусламжийн тогтолцоог шинэчлэх, үндэсний түргэн тусламжийн төв байгуулах (ЭТБГ);

408. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх (ЭТБГ);

409. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх (СЭЗБГ);

411. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өртгийн бүртгэлийн цахим тогтолцоог нэвтрүүлэх (СТГ);

412. Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй олгох эмийн хүртээмжийг нэмэгдүүлэх (СТГ);

413. Гадаад улс оронтой хамтран ажиллах гэрээ байгуулан тусламж, үйлчилгээ үзүүлэх боломж бүрдүүлэх (ЭТБГ);

416. Хиймэл оюун ухааныг эрүүл мэндийн салбарт ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах (СТГ);

417. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний анхан шатны маягтуудын өгөгдлийн тайлбар толь бий болгож, Эрүүл мэндийн Энтерпрайз архитектурын суурь мета-өгөгдөл болгон хөгжүүлэх (СТГ);

419. Эрүүл мэндийн салбарын мэдээллийн аюулгүй байдал, онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй эрүүл мэндийн байгууллагуудын кибер аюулгүй байдлыг сайжруулах (СТГ);

420. Өвчний Олон улсын 11-р ангилал нэвтрүүлэх (СТГ);

422. Эрүүл насжилтыг дэмжих зорилгоор ахмад настны цогц үнэлгээг нэвтрүүлэх, үнэлгээний дагуу эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрлийг боловсруулж хэрэгжүүлэх (ЭТБГ);

423. Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрүүдэд үйлдвэрлэлийн зохистой дадал, стандартыг нэвтрүүлэх (СТГ);

424. Эм, эмнэлгийн хэрэгслийн программ хангамжийг сайжруулах, салбар дундын мэдээллийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлж бүртгэл, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах (СТГ);

425. Эм, эмнэлгийн хэрэгслийн лабораторийн чадавхыг нэмэгдүүлэх (СТГ);

427. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэн тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх (ЭТБГ);

429. Эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн бэлтгэж байгаа их, дээд сургуулийн чанарыг олон улсын жишигт нийцүүлэх (СТГ);

432. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бэхжүүлэх стратеги төлөвлөгөө хэрэгжүүлэх (СТГ);

846. Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн чиг үүргийн хүрээнд жилд 2 удаа эрсдэлийн үнэлгээг хийх (СХГ);

951. Уламжлалт анагаах ухааны судалгаа, сургалт, үйлчилгээний цогцолборыг байгуулах (ЭТБГ);

999. Хөрсний нянгийн болон хүнд металлын бохирдлын судалгаанд үндэслэн бохирдол ихтэй газрууд бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх (НЭМБГ);

1029. Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах арга хэмжээг хэрэгжүүлэх, салбар дундын зохицуулалтыг сайжруулах (НЭМБГ);

1251. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисоос урьдчилан сэргийлэх сургалтыг эрсдэлт бүлгийг тодорхойлж, зохион байгуулах (НЭМБГ);

1254. Архидан согтуурахтай тэмцэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх (НЭМБГ).

Дөрөв. Шалгуур үзүүлэлт

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийт 15 шалгуур үзүүлэлт байгаагаас Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн 5 шалгуур үзүүлэлт, Хөтөлбөрийн үр дүнгийн 10 шалгуур үзүүлэлт байна.

Шалгуур үзүүлэлтийн үнэлгээ 2025 оны эхний хагас жилийн байдлаар 52.0 хувьтай байна.

- 100 хувийн үнэлгээтэй 4 шалгуур үзүүлэлт: 30-70 насны зүрх судасны өвчин, хорт хавдар, чихрийн шижин болон амьсгалын замын архаг өвчний шалтгаант нас баралтын түвшин (тухайн насны 10,000 хүн амд); Сүрьеэгийн тохиолдлын түвшин, 100,000 хүн амд; Хөдөө орон нутгаас төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт ирж тусламж, үйлчилгээ авсан иргэд; Хавдрын мэс засал, ангиографи болон гэмтлийн мэс заслын чиглэлээр төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг бүс нутагтаа тогтмол үзүүлэх эрүүл мэндийн байгууллага;

- 87.6 хувийн үнэлгээтэй 1 шалгуур үзүүлэлт: Алсын зайн анагаах ухаан телемедициний үйлчилгээ нэвтрүүлсэн байдал;

- 23.7-46.5 хувийн үнэлгээтэй 3 шалгуур үзүүлэлт: Зорилтот бүлгийн хүн амын урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамрагдалт; Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын нэмэгдэх хэмжээ; Эрүүл мэндийн төрөлжсөн мэдээний сангаар нэгтгэгдэж, хэрэглэгчдэд хүрсэн мэдээллийн төрөл;

- 0 хувийн үнэлгээтэй 4 шалгуур үзүүлэлт: Эхийн эндэгдлийн харьцаа, 100,000 амьд төрөлтөд; Нялхсын эндэгдлийн түвшин, 1,000 амьд төрөлтөд; Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийн зохистой дадал, стандартыг нэвтрүүлэх үйлдвэр; Эм, эмнэлгийн хэрэгслийн лабораторид шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт;

- Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 2 шалгуур үзүүлэлт: Орон нутагт 10,000 хүн амд ногдох эмч, Орон нутагт 10,000 хүн амд ногдох сувилагч.

Тав. Дүгнэлт

1. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эрүүл мэндийн салбарын 67 арга хэмжээний хэрэгжилт 2025 оны эхний хагас жилийн байдлаар 27.1 хувийн үнэлгээтэй байна.

2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 48 арга хэмжээ 0-59 хувийн үнэлгээтэй бөгөөд энэ нь нийт арга хэмжээний 75.0 хувийг эзэлж байна. Үүнээс 7 арга хэмжээний хэрэгжилт 30-59 хувь буюу “Үр дүн хангалтгүй”, нийт арга хэмжээний 10.9 хувийг, 0-29 хувь буюу “Үр дүн гараагүй” үнэлгээтэй 41 арга хэмжээ, нийт арга хэмжээний 64.1 хувийг тус тус эзэлж байна.

3. Удирдлага, зохион байгуулалт хангалтгүй байгаагаас арга хэмжээний хэрэгжилт “Үр дүн хангалтгүй” болон “Үр дүн гараагүй” гэсэн үнэлгээтэй байна.

4. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн үнэлгээ 52.0 хувьтай байна.

5. Арга хэмжээний төлөвлөгөө болон хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн 2025 онд хүрэх түвшинг ялгаатай, өөр өөр төлөвлөж байгаа нь үнэлгээ хийхэд хүндрэл учруулж байна.

6. Бодлогын баримт бичгийг төлөвлөхдөө арга хэмжээний суурь түвшинг буруу, алдаатай байснаас үнэлгээний хувь буурахад тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байна.

7. Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд төлөвлөгөө баталсан бол төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тавих хяналтыг сайжруулах зайлшгүй шаардлагатай байна.

Зургаа. Зөвлөмж

1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр “Үр дүн хангалтгүй” болон “Үр дүн гараагүй” байгаа арга хэмжээний хэрэгжилтийг 2025 оны сүүлийн хагас жилд эрчимжүүлэн ажиллах.

2. Газар, хэлтсийн дарга нар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, тавих хяналтыг сайжруулах.

3. Тайлагналтыг сайжруулж, шалгуур үзүүлэлтийн дагуу тодорхой, тоон үзүүлэлттэй, үр дүнд чиглэсэн, нотлох баримтад тулгуурлах.

4. Тухайн арга хэмжээтэй холбоотой нотлох баримтуудыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт өгч байх.

Эрүүл мэндийн яам
2025 оны 06 дугаар сар